**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 20 өдөр Дугаар 515 Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон 28,408,157.00 (хорин найман сая дөрвөн зуун найман мянга нэг зуун тавин долоон) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагынхаа дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

D:\Huraldaanii material\2020 on\2020.10.20 16r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын
20-ний өдрийн 515 дугаар
тогтоолын хавсралт

**"ДБҮЭГ" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах хөрөнгийн жагсаалт**

| № | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | ашиглалтад орсон он | Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | 2020 оны 270 дугаар тогтоолоор | Шинэчлэн тогтоосон үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тийда маркийн, 93-46 УБГ улсын дугаартай, арлын дугаар - JN1BCAC11Z0014201 | 2008 | 28,408,157.00 | 2,500,000.00 | 1,250,000.00 |
| | | | **28,408,157.00** | **2,500,000.00** | **1,250,000.00** |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **28,408,157.00 (хорин найман сая дөрвөн зуун найман мянга нэг зуун тавин долоон)** | **2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган)** | **1,250,000.00 (нэг сая хоёр зуун тавин мянга)** |